

**ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 02 ДУГААР САРЫН БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**


2026 оны 03 дугаар сарын 09

Улаанбаатар хот

Байгууллагын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлэх, үйл ажиллагааны үр дүнг нэмэгдүүлэх, үйлчилгээг сайжруулах, удирдлагыг мэдээллээр хангах зорилгоор байгууллагын үйл ажиллагааны 02 дугаар сарын биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Төлөвлөгөөнд тусгагдсан 2 зорилтын 37 арга хэмжээний 35.1 хувь нь “бүрэн хангалттай” буюу 100 хувь, 59.4 хувь нь “хангалттай” буюу 85 хувь, 5.4 хувь нь “хангалтгүй” буюу 70 хүртэл хувьтай үнэлэгдлээ. (График 1)

График 1.



Дээрхээс зорилт тус бүрээр үнэлбэл нэгдүгээр зорилтод байгууллагын үндсэн үйл ажиллагаа буюу гадаадын иргэнд холбогдох зөвшөөрөл, бүртгэл, хяналт, иргэний харьяалал, зөвлөгөө, мэдээллийн чиглэлээр 4 газар, нэгжийн 7 үйл ажиллагааг төлөвлөсөн нь 85 хувийн, хоёрдугаар зорилтоор нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэхээр 6 газар, нэгжийн 30 арга хэмжээний дундаж нь 89.1 хувь үнэлэгдсэн байна. (Хүснэгт 1)

Хүснэгт 1

Д/д	Зорилт	Нийт арга хэмжээ	85%-иас дээш	70-85% хүртэл	70% хүртэл	Дундаж хувь
1	2	3	4	5	6	7
1	Гадаадын иргэнд холбогдох асуудлаар зөвшөөрөл, бүртгэл, мэдээлэл, хяналтыг эрхлэн зохион байгуулна	7	-	7	-	85
2	Олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэн,	30	13	15	2	89.1

	чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, санхүүгийн чадавхыг бэхжүүлнэ					
Нийт		37	13	22	2	87.05

Нэгж тус бүрээр төлөвлөн гүйцэтгэсэн арга хэмжээний дундаж үнэлгээгээр авч үзвэл зорилтот түвшиндээ хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, үр дүн гарч оновчтой тодорхойлсон буюу 85 хувиас дээш үнэлэгдсэн Захиргаа, удирдлагын газар, Мэдээллийн технологийн хэлтэс, өөрийн эрхлэх чиг үүргийн хүрээнд тогтмол гүйцэтгэдэг үйл ажиллагааг төлөвлөн үр дүн гарч эхэлсэн буюу 85 хүртэл хувь үнэлэгдсэн 7 нэгж, үнэлгээ буурсан Санхүү, хангалт үйлчилгээний газрын төлөвлөсөн 2 арга хэмжээ шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, удирдлага, зохион байгуулалтаар хангах шаардлагатай. (Хүснэгт 2)

Хүснэгт 2

Д/д	Нэгжийн нэр	Нийт арга хэмжээ	85%-иас дээш	70-85% хүртэл	70% хүртэл	Дундаж хувь
1	2	3	4	5	6	7
1	Захиргаа, удирдлагын газар	21	11	10	-	92.8
2	Виз, зөвшөөрлийн газар	2	-	2	-	85
3	Иргэний харьяаллын газар	1	-	1	-	85
4	Зөрчил шалган шийдвэрлэх газар	3	-	3	-	85
5	Санхүү, хангалт, үйлчилгээний газар	3	-	1	2	61.6
6	Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтэс	0	-	-	-	-
7	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэс	2	-	2	-	85
8	Мэдээллийн технологийн хэлтэс	2	2	-	-	100
9	Зөвлөгөө, мэдээллийн хэлтэс	1	-	1	-	85
10	Захиргаа, удирдлагын газар, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэс хамтарсан	1	-	1	-	85
11	Санхүүгийн хэлтэс, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэс хамтарсан	1	-	1	-	85
12	Хилийн боомт, орон нутаг дах газар, нэгжүүд	0	-	-	-	-
Нийт		37	13	22	2	84.9

Мөн газар хэлтсүүдийн буюу Захиргаа, удирдлагын газар, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэс хамтарсан 1, Санхүү, хангалт, үйлчилгээний газар, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэс хамтарсан 1, нийт 2 арга хэмжээг хамтран гүйцэтгэсэн нь 85 хувь үнэлэгдсэн байна.

Дүгнэлт, зөвлөмж

Байгууллагын 2026 оны 02 дугаар сард төлөвлөн гүйцэтгэсэн 37 арга хэмжээний хэрэгжилт 88.3 хувьтай үнэлэгдлээ. Үнэлгээ буурсан арга хэмжээнүүдийн үр дүнг сайжруулж цаашид дараах арга хэмжээг авч ажиллах шаардлагатай. Үүнд:

1. “хангалттай” буюу 70 хувьтай үнэлэгдсэн:

Төсвийн шууд захирагчийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан гаргаж, хилийн боомт, орон нутаг дахь нэгжтэй тооцоо нийлэн тодруулга тайлбар гаргах (хэрэгжилт 70 хувь)

-Тус арга хэмжээг төлөвлөлт, шалгуур үзүүлэлтийн дагуу бүрэн тайлагнах шаардлагатай.

2. “хангалтгүй” буюу 70 хүртэл хувьтай үнэлэгдсэн:

Байгууллагын 2026 оны “Худалдан авах ажиллагаа”-ны төлөвлөгөөний дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулах (хэрэгжилт 30 хувь)

-Худалдан авах ажиллагааны гэрээ байгуулах эрх олгогдсон байгууллагуудтай төлөвлөсөн хугацаанд гэрээ байгуулан шалгуур үзүүлэлтийн дагуу тайлагнах;

-Арга хэмжээний шалгуур үзүүлэлт, зорилтод чиглэсэн хэрэгжилт, үр дүнг сайжруулахаар Санхүү, хангалт үйлчилгээний газар нь удирдлага, зохион байгуулалт, хариуцлагыг нэмэгдүүлж ажиллах шаардлагатай.

3. “хангалттай” буюу 85 хүртэл хувьтай үнэлэгдсэн 22 арга хэмжээний үр дүнг цаашид нэмэгдүүлж, хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах шаардлагатай.

--oo0oo--